

## ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРЬЖ БАЙГУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар хуулийн этгээдэд эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, даралтат сав, шугам хоолойн угсралт, засварын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ олгох, бүртгэх, зөвшөөрлийн хугацааг сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Эрчим хүчний барилга байгууламж барьж байгуулах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль болон энэ журмаар зохицуулна.

1.3. Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдэд эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно.

1.4. Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, цахилгаан, дулааны эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг барьж байгуулах, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ, түүний туршилт тохируулга хийх тусгай зөвшөөрлийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож, хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

1.5. Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна.

1.6. Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрлийг олгох, сунгах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.7. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь үнэт цаасан дээр хэвлэгдэх бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4.1-д заасан мэдээллийг тусгана.

**Хоёр. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг**

2.1 Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичгийг Ажлын хэсэгт бүрдүүлэн өгч, зохих журмын дагуу хүсэлтээ гаргана.

2.2 Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн талаар хүсэлт гаргах хуулийн этгээд энэ журмын 2.1-д заасан болон эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

2.2.1 Холбогдох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагын дагуу инженер, техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилтан нэг бүрийн диплом, гэрчилгээ, үнэмлэх батламж, мэргэшсэн болон зөвлөх инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар;

2.2.2 Тусгай зөвшөөрөл сунгах болон эрхлэх үйл ажиллагаагаа өргөтгөж, нэмэлт заалт хүссэн хуулийн этгээдийн хувьд гүйцэтгэсэн ажлын талаарх захиалагч байгууллагын тодорхойлолт, гэрээний хуулбар, барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээлгэн өгсөн комиссын дүгнэлтийн хуулбар;

2.3 Гадаадын хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлт гаргахдаа энэ журмын 2.2-д заасан баримт бичгийг бүрдүүлэхээс гадна тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон түүнтэй адилтгах баримт бичгийн баталгаат орчуулгын хуулбарыг хавсаргана.

### **Гурав. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хянан шийдвэрлэх**

3.1 Энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан ажил үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг жилд 6 удаа хүлээн авч, хянан шийдвэрлэнэ.

3.2 Тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор магадлан шалгаж, материалын бүрдэл дутуу, цахим мэдээллийн санд бүртгүүлсэн мэдээлэл алдаатай, зөрүүтэй, тусгай зөвшөөрөл олгоход тавигдах суурь нөхцөл шаардлагуудыг хангаагүй нөхцөлд хүсэлтийг буцаана. Энэ талаар байгууллагын бүртгүүлсэн албан ёсны цахим хаягаар мэдэгдэнэ.

3.3 Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол энэ тухай үндэслэлийг тодорхой зааж, албан бичгээр хариу мэдэгдэнэ.

3.4 Тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн бүрдүүлсэн баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12.3-т заасны дагуу

холбогдох байгууллагаар шалгуулж болно. Энэ үйл ажиллагаа хийгдэж буй тохиолдолд өргөдлийн шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

3.5 Энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан ажил үйлчилгээний дараах тусгай зөвшөөрлийг шинээр авах хуулийн этгээдийн өргөдлийг хагас жилд нэг удаа хүлээн авч, хянан шийдвэрлэнэ. Үүнд:

03.1.3: 0.1-100 МВт, түүнээс дээш хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

03.2.4: 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, завсар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

03.2.5: 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, завсар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

03.3.4: 0.7-80.0 кгх/см<sup>2</sup> болон түүнээс дээш даралттай зуухны угсралт, завсар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

03.4.4: 0.7-80.0 кгх/см<sup>2</sup> болон түүнээс дээш даралттай даралтат савны угсралт, завсар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

03.5.4: 0.7-80.0 кгх/см<sup>2</sup> болон түүнээс дээш даралттай шугам хоолой, ЦТП-ны угсралт, завсар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

03.8.2: 40.0 кгх/см<sup>2</sup> –аас дээш даралтанд ажилладаг тоноглолын угсралт, завсар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

03.9.2: 0.1-100 МВт болон түүнээс дээш эрчим хүчний эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах

03.9.4: 0.4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах

03.9.6: 0.7-40.0 кгх/см<sup>2</sup> болон түүнээс дээш даралттай зуухны техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах

03.9.8: 0.7-40.0 кгх/см<sup>2</sup> болон түүнээс дээш даралттай даралтат савны техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах

03.9.10: 0.7-40.0 кгх/см<sup>2</sup> болон түүнээс дээш даралттай шугам, хоолой, ЦТП-ны техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах

### **Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгох**

4.1 Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шуурхай байна.

4.2 Тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгана.

4.3 Хуулийн этгээдэд эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл болон барилга угсралтын ажил, үйлчилгээ гүйцэтгэх тусгай зөвшөөрөл олгох эсэх

талаарх санал, дүгнэлтийг Эрчим хүчний сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг гаргах бөгөөд Ажлын хэсэг нь ажлын албатай байна.

4.4 Ажлын хэсэг нь энэхүү журмын 5.1-д заасан эрх үүргийг хэрэгжүүлэн дүгнэлт гаргаж, дүгнэлтийг эрчим хүчний сайдын тушаалаар баталгаажуулна.

4.5 Тусгай зөвшөөрлөө сунгуулах хуулийн этгээд нь Засгийн газрын 2015 оны 360 дугаар тогтоолоор баталсан “Эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний балансыг тооцоолохтой холбогдох зардлыг санхүүжүүлэх журам” –ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтын дагуу салбарын судалгаа, шинжилгээний байгууллагын нормчлолын санд холбогдох орлогыг төвлөрүүлсэн тухай баримтыг өргөдлийн маяганд хавсаргана.

4.6 Тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлс болон тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг тусгай зөвшөөрлийн гэрээнд хавсаргана.

4.7 Гадаадын хуулийн этгээдэд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээ, хэрэгжих хугацаанд нь тусгай зөвшөөрөл олгож болно.

### **Тав. Ажлын хэсгийн зохион байгуулалт, эрх үүрэг**

5.1 Ажлын хэсэг нь орон тооны бус байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

5.2 Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд хурлыг дарга зарлан хуралдуулна. Ажлын хэсгийн дарга зайлшгүй шаардлагаар хурал удирдах эрхээ ажлын хэсгийн гишүүнд шилжүүлж болно.

5.3 Ажлын хэсгийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж урьдчилсан дүгнэлт гаргана.

5.3.1 Тусгай зөвшөөрөл олгох;

5.3.2 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

5.3.3 Тусгай зөвшөөрлийг сэргээх;

5.3.4 Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах;

5.3.5 Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.

5.4 Ажлын хэсгийн хурлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй тохиолдолд хүчинтэйд тооцно.

5.5 Хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр гарах дүгнэлтийн төслийг илээр санал хурааж, хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

5.6 Хурлаас гарсан шийдвэртэй зарчмын зөрүүтэй саналтай гишүүн саналаа хурлын тэмдэглэлд тусгайлан тэмдэглүүлж болох боловч энэ нь тухайн шийдвэрт нөлөөлөхгүй.

5.7 Хурлаас гарсан дүгнэлтэд дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, дүгнэлт нь ажлын хэсгийн албан хэрэгцээнд болон тусгай зөвшөөрлийн тушаал бүрийн эх хувьд хавсрагдаж, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын архивт хадгалагдана.

5.8 Ажлын хэсэг нь урьдчилсан дүгнэлт гаргахын тулд дор дурдсан үйл ажиллагааг явуулна: Үүнд:

5.8.1 энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан үйл ажиллагааны хүрээнд өргөдөл хүлээн авах;

5.8.2 энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан өргөдлийн загварын дагуу хүсэлтийг хүлээн авах;

5.8.3 өргөдөл гаргасан аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан ажил үйлчилгээг гүйцэтгэх чадвартай, нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг тогтоох.

5.8.4 тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн ажилтнууд болон мэргэжилтэй ажилчид нь тухайн үйл ажиллагааны чиглэлээр ажлын дадлага, туршлагатай эсэх, холбогдох сургалтанд хамрагдсан эсэхийг тогтоох;

5.8.5 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгохтой холбогдон санал, хүсэлт, гомдлын үндэслэлийг шалгаж тогтоох, шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх.

5.9 Ажлын хэсгийн гаргасан урьдчилсан дүгнэлтийг үндэслэн Эрчим хүчний сайдын тушаал гаргах бөгөөд зөвшөөрлийг энэ журмын гуравдугаар хавсралтаар баталсан гэрчилгээгээр баталгаажуулан олгоно.

## **Зургаа . Ажлын алба**

6.1 Ажлын албыг Эрчим хүчний яамны зөвшөөрсөнөөр эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн захирлын тушаалаар томилно.

6.2 Ажлын алба нь тусгай зөвшөөрлийн өргөдлийг хүлээн авах, бүртгэх, материалын бүрдлийг хангуулах, ирүүлсэн өргөдлийн дагуу тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагуудыг газар дээр нь шалгах, ажлын хэсгийн хуралд оруулах, хурлын бэлтгэлийг хангах, шийдвэрийг албажуулах, ажлын хэсгийн албан хэргийг хөтлөх, тусгай зөвшөөрөлтэй холбогдсон мэдээллийн сан бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, урьдчилсан дүгнэлт гаргахад шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцлөөр хангах үүргийг гүйцэтгэнэ.

6.3 Ажлын алба тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, байгууллага, иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.

6.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл, зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг мэдээллийг агуулсан тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн сантай байх ба уг мэдээллийн санг ажлын алба хариуцан эрхэлнэ.

### **Долоо. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдэд тавигдах шаардлага**

7.1 Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбогдсон норм, дүрэм, стандарт, техникийн нөхцөл, технологи, зураг төсөл, норматив, техникийн баримт бичгийг чанд мөрдөн чанарын шаардлагыг бүрэн хангаж, гүйцэтгэсэн ажлын чанарын баталгааг хариуцна.

7.2 Монгол Улсад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээд байна.

7.3 Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, татвар хураамжаа бүрэн төлсөн байна.

7.4 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл шинээр авах, сунгуулах, нэмэлт ажлын төрөл авахад тавигдах тусгайлсан шаардлагуудыг хангасан байна.

7.5 Үйл ажиллагааны чиглэл бүрийг хангасан мэргэжлийн үндсэн ажиллагсадтай байна.

### **Найм. Тусгай зөвшөөрлийг сунгах, нөхөн олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

8.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн хугацааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-т заасан хугацаагаар сунгуулах хүсэлтийг Ажлын хэсэгт гаргана.

8.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь компанийн боловсон хүчний нөөц, үйл ажиллагааны мэдээ, санхүүгийн тайланг мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

8.3 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг удаа дараа , ноцтой зөрчсөн тохиолдолд барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын баримт бичиг болон холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

8.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гээсэн, үрэгдүүлсэн шалтгаанаар нөхөн авах хүсэлт гаргасан бол тухайн гэрчилгээг гээсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулж, сонингийн хамт нөхөн олгох хүсэлтийг Ажлын хэсэгт ирүүлнэ. Ажлын хэсэг холбогдох материалыг судлан, дүгнэлт гаргана.

8.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдсөн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн тухай улсын бүртгэлийн ерөнхий газрын лавлагаа, аж ахуйн нэгжийн шинэ гэрчилгээ, дүрмийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж Ажлын хэсэгт ирүүлнэ. Ажлын хэсэг холбогдох материалыг судлан, дүгнэлт гаргана.

8.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д заасан үндэслэлээр гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

8.7 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа дуусгавар болсон тохиолдолд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу шийдвэрлэнэ.

8.8 Тусгай зөвшөөрлийн сунгалт хийлгээгүй аж ахуйн нэгж, байгууллагуудын ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Эрчим хүчний тухай хуулийн 24.3.1-т заасны дагуу дууссан өдрөөс хойш хүчингүй болсонд тооцно.

### **Ес. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах**

9.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх, тайлан мэдээ гаргах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийх үүргийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн хариуцна.

9.2 Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгох ажлыг Эрчим хүчний хүчний эдийн засгийн хүрээлэн нэг сарын дотор багтаан гүйцэтгэнэ

9.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд дараах асуудлыг тусгана.

9.3.1 Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, нормативын баримт бичиг, стандартыг баримталж ажиллах;

9.3.2 Зөвлөх болон мэргэшсэн, бусад инженер техникийн ажилтны шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийн тэмдэглэлийг хийлгэх;

9.3.3 Мэдээллийн санд барилгын үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийг тогтмол хугацаанд ирүүлэх;

- 9.3.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх дүрэм, журмыг баримталж ажиллах;
- 9.3.5 Барилга байгууламжийн норм, стандартын санд шимтгэл төлөх;
- 9.3.6 Техникийн дотоодын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах;
- 9.3.7 Ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах, амь насны болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах;
- 9.3.8 Хуульд заасан бусад эрх, үүрэг, хариуцлага.

### **Арав. Ажлын хэсгийн үйл ажиллагааны санхүүжилт**

10.1 Ажлын хэсэг, Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг үйлчилгээний хураамжаас санхүүжүүлнэ.

10.2 Үйлчилгээний хураамжийг эрчим хүчний яамаар хянуулсны үндсэн дээр Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн захирлын баталсан журмаар зохицуулж тогтооно.

### **Арван нэг. Бусад**

11.1 Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан санал, өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлнэ.

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРЬЖ БАЙГУУЛАХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ”-ЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ**



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

**ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫН ТӨРӨЛ,  
СУУРЬ НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

Улаанбаатар хот

2019 он